



ОРХОН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 09 сарын 25 өдөр

Дугаар А/590

Эрдэнэт

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1.а, 29.2 дахь заалт, аймгийн ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн ээлжит 9 дүгээр хуралдааны 9/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. БНХАУ-ын найрсаг харилцаа, хамтын ажиллагаат Ордос хотын Ардын төлөөлөгчдийн Их хурлын Байнгын хорооны дарга Ч.Бишрэлт тэргүүтэй төлөөлөгчдийн манай аймагт хийсэн ажлын айлчлалын зардлыг хавсралтаар баталсугай.

2. Уг зардалд шаардагдах 2771400 /хоёр сая долоон зуун далан нэгэн мянга дөрвөн зуун/ төгрөгийг төсөл, хөтөлбөрийн зардал доторх Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх олон талт арга хэмжээ зохион байгуулах зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ

Аймгийн Засаг даргын 2018 оны  
09 дүгээр сарын 25-ны өдрийн 590 дугаар  
захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТӨСӨВ

	Арга хэмжээ	Газар	Дүн
1	17-ны өдрийн оройн зоог, 18,19-ний өдрүүдийн өглөөний хоол, 19-ний өдрийн үдэлтийн зоогийн зардал	"Жемстоун" Коктейл лоунж	619400 төг
2	18-ны өдрийн зоог	Баялаг лоунж	297700 төг
3	Засаг даргын нэрэмжит хүндэтгэлийн хүлээн авалт	N-house ресторан	579500 төг
4	Бусад: Уулзалтын үеэр тавигдсан ус, нэг удаагийн аяга		20800 төг
5	Зочид буудлын зардал: 9 ш өрөө=627,0 х 2 хоног	GOLD зочид буудал	1254000 төг
	НИЙТ		2771400 төг